

ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. “АЖЛЫН БАЙРНЫ ТАНИЛЦУУЛГА”

Байгууллагын нэр	Нэгжийн нэр		
“Замын-Үүдийн дулааны станц” ТӨААТҮГазар	Санхүү борлуулалтын хэлтэс, Төлөвлөлт бүртгэл тооцооны алба		
Ажлын байрны нэр:	Ангилал	Зэрэглэл	Дугаар
Тооцооны ня-бо /Бараа материал/			
Шууд харъяалагдах ажлын байр /албан тушаал/	Шууд харъяалах ажлын байр /албан тушаал/		
Ерөнхий нягтлан бодогч	-		

Б. “АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ”

Ажлын байрны үндсэн зорилго	Үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, байгууллагын бараа материалын орлого, зарлага болон агуулахын эмх цэгцтэй байдал, хадгалалт хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах.
Ажлын байрны үндсэн чиг үүрэг	Ажлын байрны үндсэн зорилт 1. Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Монгол улсын санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал, ЗҮДС-н Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн байгууллагын хэмжээний бараа материал, сэлбэг, түлш, шатахуун, шатах тослох материал, БҮТЭЗ зэрэг үнэ бүхий зүйлсийн тайлан тооцоог боловсруулан хөтлөж, бүртгэлээр хяналт тавих 2. Удирдлагыг оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай шуурхай, үнэн зөв мэдээллээр хангаж, Шалган байцаах комисс, Аудит болон бусад эрх бүхий байгууллагуудад шаардлагатай мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөх. 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, журам, дүрмийг биелүүлэх
Ажлын байранд хийгдэх ажлууд	Ажлын байрын 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд: 1.1. Санхүүгийн баримт эргэлтийн графикт заагдсан хугацааг мөрдөж ажиллана. /Сарын турш/ 1.2. Материал, сэлбэг, түлш, шатахуун, шатах тослох материал үнэ бүхий зүйлсийн бүртгэл тооцоотой холбогдсон анхан шатны бүртгэлийг зохих журам зааврын дагуу хөтлөнө. /Сар бүр/ 1.3. Материал, сэлбэг, түлш, шатахуун, шатах тослох материал үнэ бүхий зүйлсийн бүртгэл хөдөлгөөнийг бараа материалд хөтлөгдөх анхан шатны маягтаар няравууд болон хэсэг цехийн ахлагч нараар тайлан гаргуулан эрх бүхий албан тушаалтануудаар хянуулж гарын үсэгээр баталгаажуулсан тайланг хүлээн авах./Сар бүр/ 1.4. Материал, сэлбэгийн хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавих явцдаа зарцуулалтын объект, объектын хэмжээ, шинж чанарыг тодорхойлуулан зарцуулалтын орцын нормын хэрэгжилтэнд ИТА-н тусламжтайгаар хөрөнгийн тоо,чанар,объектын зардлын хяналт, шалгалтыг хийлгэж, зарцуулалтын бүртгэлийг хөтлөнө. /Сар бүр/

	1.5. Түлш шатахуун, шатах тослох материалын хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавих явцдаа зарцуулалтын объект, мото цаг, спидометрийн заалт, зарцуулалтын орцын нормыг мөрдөж зардлын хяналт, шалгалтыг хийж, орлого, зарцуулалтын бүртгэлийг хөтлөнө. /Сар бүр/ 1.6. Тайлан баланс гаргахад өөрийн хариуцсан дансны үлдэгдэл,насжилт,нормативын өөрчлөлт, удаан гүйлгээтэй болон огт гүйлгээгүй зэрэг мэдээлэл, тодруулгыг гаргаж өгнө. /Сар улирал,жилээр/ 1.7. Материал, сэлбэг,хангамжийн зардалын хуваарилалтыг их барилга, их засвар, үйлдвэрийн чиглэлээр материал төрөл тус бүрээр, хэсэг цехээр, сар улирал өссөн дүнгээр нэгтгэн гаргана. /Сар улирал,жил/ 1.8. Балансын тодруулага, хавсралтуудыг нөхөх, балансын тайлбарт дүн шинжилгээ бичин, судалгаа гаргахад биечлэн оролцоно./Улирал,жилээр/ 1.9. Гадны байгууллагтай үүссэн Материал, сэлбэг үнэ бүхий зүйлсийн авлага, өглөгөөр тооцоо нийлж актыг бүрдүүлэн балансад хавсаргана. /Улирал бүр/ 1.10. Материал, сэлбэг түлш, шатахуун, шатах тослох материал үнэ бүхий зүйлсийн үлдэгдлийг бодит байдалтай тулган шалгаж бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт эмх цэгцийг сайжруулах ажлыг хийнэ. /Улиралд 1 удаа төлөвлөгөөт бус тооллого хийж/ 1.11. Нягтлан бодох бүртгэлийн үлдэгдэлтэй аж ахуйн няравын агуулахын бүртгэлийн үлдэгдлийг карт тус бүрээр тулган шалгаж баталгаажуулан гарын үсгээ зурна. /Сар бүр/ 1.12. Эд хариуцагч нарын тайлангийн үлдэгдлийг НББ-ын үлдэгдэлтэй тулган шалгаж харилцан гарын үсэг зурж баталгаажуулна. /Сар бүр/ 1.13. Материал, сэлбэгийн үлдэгдлийг балансын дансны үлдэгдэлтэй тулгалт хийж ерөнхий нягтлан бодогчоор баталгаажуулна. /Сар бүр/ 1.14. Складын үлдэгдлийг хянаж норм хэмжээнд барих, нэг жилээс дээш эргэлтэнд ороогүй түүхий эд материалын жагсаалтыг гарган байгууллагын удирдлагад танилцуулна./Улиралд/ 1.15. Материалын эргэцийг сар, улиралаар гарган шаардлагатай арга хэмжээг авахуулна./Улиралд/ 1.16. Материал сэлбэгийн зарцуулалтад судалгаа, шинжилгээ хийж, саналаа боловсруулан байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогчид танилцуулж холбогдох арга хэмжээг авахуулна. 1.17. Материал сэлбэг, үнэ бүхий зүйлсийн хадгалалт хамгаалалт, хэвийн хорогдол, эвдрэл гэмтлийн талаар таницуулж арга хэмжээ авах комисс томилуулах ажлыг зохион байгуулна. 1.18. Тайлангуудын зарцуулалтаар БҮТЭЗ-ийн зардалаар гарч байгаа материал, багаж сэлбэг хэрэгсэлийг гарсан зардалтай тулган балансын гадуур бүртгэнэ. /Жилд тооллогоор шалгана./ 1.19. Тайлангийн зарцуулалтаар гарч байгаа хугацаатай солигддог сэлбэг хэрэгслийг тусгай файл гарган хөтлөн тэмдэглэж хугацааг тооцон тасралтгүй ханган нийлүүлэх арга хэмжээг авна. /Солигдох хугацаанд/ 1.20. Материал сэлбэг ханган нийлүүлэх журмыг мөрдлөгө болгож материалын захилгын хуудсыг дугаарлан бүртгэж үр дүн тооцож ажиллах /сар бүр/ 1.21. Складад гэнэтийн болон хэсэгчилсэн тооллого тооцоог хийж материал сэлбэг, хангамжийн зүйлсийн үлдэгдэлийг бодит байдалтай тулган шалгаж акт үйлдсэн байна./Улиралд 1-2 удаа/ 1.22. Хэсэг цехийн материал,сэлбэгийн тайлангийн зарцуулалтанд хэсэгчилсэн шалгалт хийж бодит зарлагатай тулган хянаж акт үйлдэнэ.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг байгууллагын захиргаанд танилцуулж шийдвэрлүүлнэ. /Улиралд 1 удаа/
--	---

	1.23. Эргэлтийн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хийж, тооллогын үр дүнг гарган танилцуулж, тооллоготой холбоотой тооцоо хөдөлгөөнийг хийж тооллогын мэдээ тайланг байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогчоор баталгаажуулан санхүүгийн баримтанд хавсаргана. /Жил бүр/ 1.24. Бараа материал үнэ бүхий зүйлийн бүртгэл тооцоонд гарч буй алдааг засаж залруулахдаа НББ-ийн хуульд заасны дагуу холбогдох баримт материалыг үндэслэн зөв үзүүлэлтийг бичиж, тооцоолол хийсэний үндсэн дээр уг бүрдүүлсэн бичиг баримт материалд залруулга хийсэн болон зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан баримтаар хийнэ./Тухай бүр/ 1.25. Нягтлан бодох бүртгэлийн болон салбарын онцлогт тохирсон программ хангамжийг шинэчлэн сайжруулах, тайлан тооцооны ажил хөдөлмөрийг хөнгөвчлөх, тайлангийн хавсралт маягтуудыг боловсронгуй болгоход санал өгнө. /Тухай бүр/ 1.26. Нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой арга аргачлал, заавар, хууль, дүрэм, журам, тогтоол шийдвэр бусад баримт бичгийг судалж, өөрийн мэдлэг мэргэжлээ дээшлүүлж ажиллана. /байнга/ 1.27. Үйлдвэрлэл санхүү, эдийн засгийн төсөв, төлөвлөгөө, үзүүлэлт, тээврийн тариф, цалин хөлс бусад нууцад хамаарах бичиг баримтын нууцлалыг чанд хадгална. /байнга/ 1.28. Архивын хуулийн дагуу баримтыг архивт шилжүүлэх, электрон хэлбэрээр боловсруулсан тайлан мэдээг зөөврийн хардад файл болгон хадгална. Материал, сэлбэг, үнэ бүхий зүйлсийн тайлангууд, НББүртгэл, тооллогын баримтууд, ажил хүлээлцсэн баримтуудын хуудсыг дугаарлан үднэ /сар, улирал, жил/ 1.29. Харилцагч байгууллагаас үзүүлсэн ажил үйлчилгээний нэхэмжлэхийг хянаж, үнэн зөв баримтын дагуу данс бүртгэлд бүртгэж, тооцоог хийх 1.30. Дараа тайлангийн гаргагчийн тооцоог анхан шатны баримтуудыг үнлэслэн бодож, гаргах. 1.31. Суутгагчын хувь хүнд олгосон орлогын албан татварын тайланг үнэн зөв гаргах, түүнтэй холбоотой татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт бичилт хийнэ.Суутган тооцогчийн тайланг хийж хуулийн хугацаанд илгээнэ. 1.32. Шилэн дансанд өөрийн хариуцдаг дансдын гүйлгээний мэдээллийг оруулах /бараа материалын 5 сая дээш худалдан авалтууд, бусад / 1.33. Ерөнхий нягтлан бодогч болон үндсэн хөрөнгө, цалин хөлс хариуцсан нягтлан бодогчыг эзгүйд орлож ажиллана. Ажлын байрны 2 дугаар үндсэн зорилтын хүрээнд: 2.1. Эд хариуцагч нар болон санхүүгийн ажилтан нарын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж зааж сургах, заавар зөвлөгөө өгч ажиллана. 2.2. Анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар санхүүгийн ажилтануудад хяналт тавьж, ИТА, хэсэг цехийн ахлагч нарт сургалт зохион байгуулахад туслах биечлэн оролцох. /Тухай бүр/ 2.3. Материал, сэлбэг үнэ бүхий зүйлсийн тайлангуудын анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар хэсэг цехийн ахлахуудын сарын үр дүнгийн шагналын хэмжээг тогтооход, тэдний бүртгэл тооцооны ажлын оролцоог тодорхойлж, ерөнхий нягтлан бодогчоор дамжуулан өөрийн саналаа өгнө./Сар бүр/ 2.4. Ерөнхий нягтлан бодогчийг ээлжийн амралттай болон бусад шалтгаанаар эзгүй үед орлон ажиллана. Төлбөрийн даалгавар, мөнгөн чекнээс бусад баримтанд 2-р гарын үсэг зурах эрхтэйгээр ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг гүйцэтгэнэ. Ажлын байрны тодорхойлолттой танилцсан байна /Тухай үед/
--	--

	2.5. ЗҮДС-ын НБББ-ын баримт бичгийг судлах, санхүүгийн ажилтан нарт ойлгуулах, мөрдөж хэвшүүлэх ажилд сургах./Жилийн турш/ 2.6. Байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогчоос цаг үеийн асуудалтай холбогдуулан өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж эргэж мэдэгдэнэ./Тухай бүр/ 2.7. Ёс зүйн зөрчил болон хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргахгүй ажиллахын тулд өөрийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ./Жилийн турш/ 2.8. Ажлын төлөвлөгөө гарган ажиллаж ажлын тайланг тогтмол бичиж байна. /сар, улирал,жил/ 2.9. Компьютерийн үзлэг үйлчилгээ, сүлжээний асуудлыг мэргэжлийн хүмүүсээр тогтмол хийлгэж ,ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хариуцана./Өдөр бүр/ 2.10. Байгууллагын хэмжээнд зохиогдох цаг үеийн ажилд идэвхтэй оролцоно./Тухай бүр/ 2.11. Цахилгаан борлуулалтын тусгай зөвшөөрөл авахтай холбоотой баримт материал бүрдүүлэх, орлого зардлын дүн мэдээг гаргаж өгнө. 2.12. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүүгийн тайланг Хот сууриний ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг Зохицуулах зөвлөлд улирал тутамд гаргаж тушаахад өөрийн хариуцсан дансдын мэдээлэлийг гаргаж өгнө. Ажлын байрны 3 дугаар үндсэн зорилтын хүрээнд: 3.1. Гэрээсээ ажилд ирж буцах маршрутыг өөрөө гарган холбогдох ажилтнаар батлуулан ажил олгогчид өгөх, гэрийн байршил өөрчлөгдөх бүрт энэ заалтыг хэрэгжүүлэн ажиллана. 3.2. Галын аюулгүй байдлыг хангаж ажиллана. 3.3. ЗҮДС-н ажилтан бүр ХАБЭА-н талаар дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд: 3.3.1. ХАБЭА-н холбогдох стандарт, журам, дүрэм, заавар, мөн түүнчлэн технологийн горимыг чанд мөрдөх, барилга байгууламж, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн болон бусад хорт ба аюултай бодис, материал, тээврийн хэрэгсэл болон бусад үйлдвэрлэлийн хэрэгслийг аюулгүй, зөв ашиглах, тэдгээрт тоноглогдсон хамгаалалтын ба аюулгүйн хэрэгслийг салгах, солих, авахгүй байх бөгөөд шаардлагатай үед тэдгээрийг хэрхэн зөв ашиглах талаар мэддэг байх; 3.3.2. ХАБЭА-н сургалтад хамрагдаж, шалгалт өгөх, зааварчилгаа авах, ажил үүргээ аюулгүй, осол эндэгдэлгүй гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар, арга барил эзэмших, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс сэргийлэх, болзошгүй ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшиж сурах; 3.3.3. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад ХАБЭА-н стандарт, журам, дүрэм, заавар зөрчигдсөн болон амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар шууд харьяалагдах албан тушаалтанд мэдэгдэж аюулгүй байдлыг хангуулах, удирдах албан тушаалтны зүгээс хууль тогтоомжид нийцүүлэн тавьсан ХАБЭА-н шаардлагыг биелүүлэх; 3.3.4. Ажлын байрны ХАБЭА-н эрсдлийг удирдах, хяналтын арга хэрэгслийн талаар мэдэх, ажлын байранд болон ажил гүйцэтгэх явцад илэрсэн аливаа аюул, эрсдэл, гарсан аюултай тохиолдлын талаар шууд харьяалагдах албан тушаалтанд мэдээлэх, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;
--	---

	3.3.5. Ажил үүргээ биелүүлэх явцад ажлын тусгай хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгслийг зөв, бүрэн гүйцэд, зориулалтын дагуу хэрэглэж эрүүл мэндээ хамгаалах, жил бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орж, эмчийн өгсөн зааврын дагуу нөхөн сэргээх эмчилгээ хийж байх; 3.3.6. Ажил эхлэхээс өмнө эрсдлээ үнэлэх буюу ээлжийн туршид ажлын байр, багаж, тоног төхөөрөмж, агааржуулалтын систем, гэрэлтүүлэг, хамгаалалтын хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үзэж, шалгах. Илэрсэн зөрчил дутагдлын талаар ажил удирдагчид мэдээлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авахуулах; ХАБЭА-н I шатны үзлэг хийж, зөрчлийг арилгуулах 3.3.7. ХАБЭА-н нөхцөл, үйлдвэрлэлийн аюулгүй байдалд шаардпагыг тогтоосон дүрэм, журам, зааврын шаардлагуудтай зөрчилдсөн нөхцөл байдал илэрсэн, мөн түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөгдөөгүй тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхгүй байх 3.3.8. Харьлагдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр ажлын байр болон ажиллаж буй тоног төхөөрөмжийг хараа хяналтгүй орхихгүй байх, хөндлөнгийн хүмүүс тоног төхөөрөмжийг залгах боломжийг хязгаарлах арга хэмжээ авах; гэрээсээ ажилд ирж буцах маршрутыг өөрөө гарган холбогдох ажилтнаар батлуулан ажил олгогчид өгөх, гэрийн байршил өөрчлөгдөх бүрт энэ заалтыг хэрэгжүүлэн ажиллана.
--	--

В. “АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА”

Ажлын байранд тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага	Боловсрол	Дээд
		Мэргэжил	Санхүү, нягтлан бодох бүртгэл
		Мэргэшил	-
		Туршлага	-Мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан байх
	Ур чадвар	-Багаар ажиллах чадвартай байх, - Хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай /MS-WORD, бусад санхүүгийн программ/	
	Тусгай шаардлага		Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн байх, Багаар ажиллах, нууц хадгалах, удирдах, удирдуулах зарчмыг баримтлах, эерэг хандлага, зөв төлөвшилтэй, ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, ажлын ачаалал даах,

Г. “АЖЛЫН БАЙРНЫ ХҮЧИН ЗҮЙЛС”

Харилцах объект /хүрээ, уялдаа холбоо/	Байгууллагын дотор	Байгууллагын гадна
	Байгууллагын нийт ажилчид	Харилцагч байгууллагын холбогдох ажилтнууд
Ажлын үр дүнгийн талаар ажил	Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод журам, ТАД, ААД, ГАУСД болон ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ	

эрхлэгчийн хүлээх хариуцлага	биелүүлээгүй тохиолдолд хөдөлмөрийн сахилгын, захиргааны болон эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ Ажлын хариуцлага алдсанаас учруулсан эд хөрөнгийн хохирлыг бүрэн хариуцна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг сахиж мөрдөөгүй, хариуцсан ажлаа ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэхгүйгээс зөрчил дутагдал гаргасан тохиолдолд хариуцлага хүлээнэ. Ажлын байранд архи уусан, танхайн сэдэлтэй үйлдэл хийсэн тохиолдолд хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болно.
-------------------------------------	---

Ажлын байрны нөөц хэрэгсэл	Санхүү	Батлагдсан тарифт цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал
	Эд хөрөнгө	Картаар хүлээлгэн өгсөн эд хөрөнгө
	Хүн хүч	
	Бусад	
Ажлын байрны нөхцөл		Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллана

БОРЛУУЛАЛТЫН АЖИЛТНЫ АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. “АЖЛЫН БАЙРНЫ ТАНИЛЦУУЛГА”

Байгууллагын нэр	Нэгжийн нэр		
“Замын-Үүдийн дулааны станц” ТӨААТҮГазар	Санхүү борлуулалтын хэлтэс, Борлуулалтын алба		
Ажлын байрны нэр:	Ангилал	Зэрэглэл	Дугаар
Борлуулалтын ажилтан /айл өрх хариуцсан/			
Шууд харъяалагдах ажлын байр /албан тушаал/	Шууд харъяалах ажлын байр /албан тушаал/		
Борлуулалтын ахлах ажилтан	-		

Б. “АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ”

Ажлын байрны үндсэн зорилго	Үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, үйлчлүүлэгчиддээ түргэн шуурхай, найдвартай, чанартай үйлчилгээг хүргэх, байгууллагын ашиг, орлогыг нэмэгдүүлэх.
Ажлын байрны үндсэн чиг үүрэг	Ажлын байрны үндсэн зорилт 1. Дулаан, цэвэр ус, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлсэний төлбөр тооцоог хэрэглэгчидтэй хийж НББүртгэлд тусгах, авлагын тооцоо гаргах, байгууллагын борлуулалтын орлогын тайлан гаргах, хэрэглэгч тус бүртэй авлагын тооцоог нийлж баталгаажуулна. 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм биелүүлж ажиллах.
Ажлын байранд хийгдэх ажлууд	Ажлын байрын 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд: 1.1. Санхүүгийн баримт эргэлтийн графикт заагдсан хугацааг мөрдөж ажиллана. /Сарын турш/ 1.2. Айл өрхүүдийн картны бичилтийг үнэн зөв хөтлөх. 1.3. Сар бүрийн 12-ны өдрийн дотор хариуцсан айл өрхүүдийн цэвэр, бохир усны заалт авч хариуцсан нягтлан бодогчид тайлагнах. 1.4. Сар бүр хариуцсан айл өрхүүдийн дулаан, цэвэр бохир ус ашигласаны төлбөрийн нэхэмжлэхийг хэрэглэгчидэд мэдэгдэх 1.5. Борлуулалтын орлогыг компанийн дансанд төвлөрүүлэх, авлагыг бууруулах 1.6. Банкуудын харилцахын хуулгыг шүүж авлагын тооцоог хийх /Өдөр бүр / 1.7. Харилцахаар орсон орлогыг бүртгэж боловсруулан борлуулалтын программд шивэлт хийж үлдэгдлийг баталгаажуулна. /Өдөр бүр/ 1.8. Насжилттай байгаа хувь хэрэглэгч нарын авлагыг барагдуулах 1.9. Насжилт өндөр авлагыг үүсгэхгүй үүднээс шугам дээр салгалт хийлгэх, хязгаарлах арга хэмжээг авахтай холбоотой хэрэглэгч нарт мэдэгдэл өгөх 1.10. Нягтлан бодох бүртгэлийн болон салбарын онцлогт тохирсон программ хангамжийг шинэчлэх, сайжруулах, тайлан тооцооны ажил хөдөлмөрийг хөнгөвчлөх, тайлангийн хавсралт маягтуудыг боловсронгуй болгоход санал өгнө. /Тухай бүр/ 1.11. Нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой арга аргачлал, заавар, хууль, дүрэм, журам, тогтоол, шийдвэр бусад баримт бичгийг судалж, өөрийн мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж ажиллана. /байнга/

	1.12. Үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн төсөв, төлөвлөгөө, үзүүлэлт, холбогдох тариф, цалин хөлс бусад нууцад хамаарах бичиг баримтын нууцлалыг чанд хадгална. /байнга/ 1.13. Архивын хуулийн дагуу баримтыг архивт шилжүүлэх, электрон хэлбэрээр боловсруулсан тайлан мэдээг зөөврийн хардад файл болгон хадгална. 1.14. Айл өрхтэй хийсэн гэрээ, тооцоо нийлсэн акт, айл өрхийн усны тоолуурын карт зэрэг санхүүгийн бусад баримтыг үдэж архивт өгнө. /сар, улирал, жил / 1.15. Хэрэглэгчтэй авлагын тооцоо нийлж баталгаажуулна. 1.16. Борлуулалтын авлагыг цаг хугацаанд нь цуглуулах талаар идэвхи санаачлагатай ажиллана. 1.17. Шүүхийн маргаантай байгаа, найдваргүй болсон авлагын бүртгэлийг хийж борлуулалтын ахлах мэргэжилтэнд өгч асуудлыг шийдвэрлүүлнэ. 1.18. Байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан, борлуулалтын нягтлан бодогчоос цаг үеийн асуудалтай холбогдуулан өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж эргэж мэдэгдэнэ./Тухай бүр/ 1.19. Ёс зүйн зөрчил болон хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргахгүй ажиллахын тулд өөрийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ./Жилийн турш/ 1.20. Ажлын төлөвлөгөө гарган ажиллаж ажлын тайланг тогтмол бичиж тооцоо судалгаатай ажиллах /сар, улирал, жил/ 1.21. Компьютерийн үзлэг үйлчилгээ, сүлжээний асуудлыг мэргэжлийн хүмүүсээр тогтмол хийлгэж ,ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хариуцана./Өдөр бүр/ 1.22. Байгууллагын хэмжээнд зохиогдох цаг үеийн ажилд идэвхтэй оролцоно./Тухай бүр/ 1.23. Дулаан, цэвэр, бохир усны зүй бус хэрэглээг илэрүүлэх, үргүй зардал гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. 1.24. Хариуцсан хэсгийн айл өрхүүдтэй дулаан цэвэр бохир усны гэрээ байгуулах. 1.25. Айл өрхүүдтэй авлага, өглөгийн тооцоог хийх, баталгаажуулах. 1.26. Төлбөр төлөөгүй хэрэглэгчдийн нэрс, жагсаалтыг гаргаж цаашид авах арга хэмжээг өөрийн удирдах албан тушаалтантай зөвшилцсөний үндсэн дээр үйлчилгээг зогсоох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлж ажиллах. 1.27. Баталгаажсан өр авлагыг барагдуулах талаар судалгаа хийн цаашид авах арга хэмжээний талаар харьяалагдах албан тушаалтанд санал оруулах. 1.28. Эрчим хүчний тухай болон бусад холбогдолтой хууль тогтоомж дүрэм журмыг хэрэглэгчидэд суртачилан таниулах. 1.29. Айл өрхийн борлуулалтын мэргэжилтэнг эзгүйд орлож ажиллана. 2-р зорилтын хүрээнд: 2. Үйлдвэрийн ажилтан бүр ХАБЭА-н талаар дараах нийтлэг үүрэгтэй байна.Үүнд: 2.1. Гэрээсээ ажилд ирж буцах маршрутыг өөрөө гарган холбогдох ажилтанаар батлуулан ажил олгогчид өгөх, гэрийн байршил өөрчлөгдөх бүрт энэ заалтыг хэрэгжүүлэн ажиллана. 2.2. Галын аюулгүй байдлын хангаж ажиллана. 2.3. ХАБЭА-н холбогдох стандарт, журам, дүрэм, заавар, мөн түүнчлэн технологийн горимыг чанд мөрдөх, компьютер тоног төхөөрөмжийг түүнтэй адилтгах хөрөнгийг хэрхэн зөв ашиглах талаар
--	--

	мэддэг байх; 2.4. ХАБЭА-н сургалтад хамрагдаж, шалгалт өгөх, зааварчилгаа авах, ажил үүргээ аюулгүй, осол эндэгдэлгүй гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар, арга барил эзэмших, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс сэргийлэх, болзошгүй ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшиж сурах; 2.5. Ажлын байрны ХАБЭА-н эрсдлийг удирдах, хяналтын арга хэрэгслийн талаар мэдэх, ажлын байранд болон ажил гүйцэтгэх явцад илэрсэн аливаа аюул, эрсдэл, гарсан аюултай тохиолдлын талаар шууд харьяалагдах албан тушаалтанд мэдээлэх, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх; 2.6. Ажил үүргээ биелүүлэх явцад ажлын тусгай хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгслийг зөв, бүрэн гүйцэд, зориулалтын дагуу хэрэглэж эрүүл мэндээ хамгаалах, жил бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орж, эмчийн өгсөн зааврын дагуу нөхөн сэргээх эмчилгээ хийж байх; 2.7. Ажил эхлэхээс өмнө эрсдлээ үнэлэх буюу ээлжийн туршид ажлын байр, багаж, тоног төхөөрөмж, агааржуулалтын систем, гэрэлтүүлэг, хамгаалалтын хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үзэж, шалгах. Илэрсэн зөрчил дутагдлын талаар ажил удирдагчид мэдээлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авахуулах; ХАБЭА-н I шатны үзлэг хийж, зөрчлийг арилгуулах
--	--

В. “АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА”

Ажлын байранд тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага	Боловсрол	Бүрэн дунд, түүнээс дээш
		Мэргэжил	
		Мэргэшил	-
		Туршлага	-
		Ур чадвар	- Хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай байх./MS-Word, Excel/
	Тусгай шаардлага	Бие даан ажиллах болон багаар ажиллах чадвартай, эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн, Үнэнч шударга байх, бичиг баримт боловсруулах, бүртгэл тооцоо хөтлөх, судалгаа гаргах, дүгнэлт хийх чадвартай байх	

Г. “АЖЛЫН БАЙРНЫ ХҮЧИН ЗҮЙЛС”

Харилцах объект /хүрээ, уялдаа холбоо/	Байгууллагын дотор	Байгууллагын гадна
	Байгууллагын нийт ажилчид	Харилцагч байгууллагын холбогдох ажилтнууд

Ажлын үр дүнгийн талаар ажил эрхлэгчийн хүлээх хариуцлага	Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод журам, ТАД, ААД, ГАУСД болон ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хөдөлмөрийн сахилгын, захиргааны болон эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ Ажлын хариуцлага алдсанаас учруулсан эд хөрөнгийн хохирлыг бүрэн хариуцна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг сахиж
---	--

	мөрдөөгүй, хариуцсан ажлаа ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэхгүйгээс зөрчил дутагдал гаргасан тохиолдолд хариуцлага хүлээнэ. Ажлын байранд архи уусан, танхайн сэдэлтэй үйлдэл хийсэн тохиолдолд хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болно.
--	--

Ажлын байрны нөөц хэрэгсэл	Санхүү	Батлагдсан тарифт цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал
	Эд хөрөнгө	Картаар хүлээлгэн өгсөн эд хөрөнгө
	Хүн хүч	
	Бусад	
Ажлын байрны нөхцөл		Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллана
Онцгой нөхцөл		Үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагаатай холбогдуулан дуудсан үед ажлын бус цаг, амралтын өдрийг үл харгалзан ирж ажиллах. /Албан тушаалын болон хувийн үүрэн телефон утсыг байнгийн ажиллагаатай байлгах/ -Шаардлагатай үед илүү цагаар болон томилолтоор ажиллах.

ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. “АЖЛЫН БАЙРНЫ ТАНИЛЦУУЛГА”

Байгууллагын нэр	Нэгжийн нэр		
“Замын-Үүдийн дулааны станц” ТӨААТҮГазар	Санхүү борлуулалтын хэлтэс, Төлөвлөлт бүртгэл тооцооны алба		
Ажлын байрны нэр:	Ангилал	Зэрэглэл	Дугаар
Тооцооны ня-бо /Борлуулалт хариуцсан/			
Шууд харъяалагдах ажлын байр /албан тушаал/	Шууд харъяалах ажлын байр /албан тушаал/		
Ерөнхий нягтлан бодогч	-		

Б. “АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ”

Ажлын байрны үндсэн зорилго	Үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, үйлчлүүлэгчиддээ түргэн шуурхай, найдвартай, чанартай үйлчилгээг хүргэх, байгууллагын ашиг, орлогыг нэмэгдүүлэх.
Ажлын байрны үндсэн чиг үүрэг	Ажлын байрны үндсэн зорилт 1. Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Монгол улсын санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал, ЗҮДС-н Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн байгууллагын хэмжээний бараа материал, сэлбэг, түлш, шатахуун, шатах тослох материал, БҮТЭЗ зэрэг үнэ бүхий зүйлсийн тайлан тооцоог боловсруулан хөтлөж, бүртгэлээр хяналт тавих 2. Удирдлагыг оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай шуурхай, үнэн зөв мэдээллээр хангаж, Шалган байцаах комисс, Аудит болон бусад эрх бүхий байгууллагуудад шаардлагатай мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөх. 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай х журам, дүрмийг биелүүлэх
Ажлын байранд хийгдэх ажлууд	Ажлын байрын 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд: 1.1. Санхүүгийн баримт эргэлтийн графикт заагдсан хугацааг мөрдөж ажиллана. /Сарын турш/ 1.2. Байгууллагын дулааны борлуулалтыг тарифын дагуу нэгтгэн гаргаж тайланг хийж, борлуулалтын байцаагч нарт өгч нэхэмжлэхийг тараалгуулах /Сар бүр/ 1.3. Дулаан борлуулалтын программаас борлуулалтыг балансын программ руу шивэлт хийж нийт болон мэргэжилтэн нарын дүн, тарифуудыг хянаж шалган холбогдох тохиргоо бичилтүүдийг салгаж хийнэ. /Сар бүр/ 1.4. Байгууллагуудын дулаан, ус борлуулалтын орлогын төлөлтийн талаар бүртгэлийг нарийн цаг хугацаатай хөтлөж гэрээний биелэлтийг

	шалгаж хугацаа хоцорсон орлогод алданги тооцох буюу бусад шат дараалсан арга хэмжээг авч ажиллана. /Сар бүр/ 1.5. Байгууллагын хэмжээний усны борлуулалтын заалтын бичилтийг борлуулалтын мэргэжилтэнүүдээс хүлээн авахдаа смарт программ, болон карттай тулган шалгаж баталгаажуулсаны дараа тооцоололыг хийж, тайланг гарган борлуулалтын мэргэжилтэнүүдэд өгнө. /Сар бүр/ 1.6. Усны борлуулалтын тайланг балансын программд шивж оруулна./Сар бүр/ 1.7. Борлуулалтын заалтыг чиглэл хариуцсан борлуулалтын мэргэжилтэн нараас баталгаажуулсаны дараа шалгаж хүлээн авч тайланг хийж гаргана. /сар бүр/ 1.8. Борлуулалт болон авлагын бүртгэл тооцоонд гарч буй алдааг засаж залруулахад НББ-н хуульд заасны дагуу НББ-ийг хөтлөх болон бодох явцад гарсан алдааг залруулахдаа холбогдох баримт материалыг үндэслэн зөв үзүүлэлтийг бичиж, тооцоолол хийсэний үндсэн дээр уг бүрдүүлсэн бичиг баримт материалд залруулага хийсэн болон зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан баримтаар залруулга хийнэ. /Тухайн үед/ 1.9. Байгууллагын хэмжээнд борлуулалтын орлогыг нэр, төрлөөр, ААНБ тус бүрээр гэсэн чиглэлээр, орлого оруулагч нарын нэрээр тухайн сараар харуулан бүртгэнэ /сар бүр/ 1.10. Байгууллагын НӨАТ-ын тайланг хийж сар бүр татварын албанд тайлагнана /хуулийн хугацаанд/ 1.11. Байгууллагатай тооцоо нийлэх үлдэгдлийн батлагааг НББ-ын үлдэгдэл болон балансын үлдэгдэлтэй тулган шалгуулж, тооцоо нийлсэний дараа үлдэгдлийн баталгааг тусад нь үдэж архивлана. /Улирал бүр/ 1.12. Байгууллагын хэмжээний дулаан, усны зардлыг хэсэг цех тус бүрээр ангилан бүртгэнэ./Сар бүр/ 1.13 Нийт авлагын талын мэдээллийг борлуулалтын ахлах мэргэжилтэн, борлуулалтын байцаагчид гарган өгч авлага цуглуулах ажлыг зохион байгуулна./Сар бүр/ 1.14. Мөнгөн хөрөнгийн орлогын гүйлгээг нэг бүрчлэн шалгаж банкны хуулгатай тулган баталгаажуулж, журналд бичилт хийхдээ харилцагч банк тус бүрээр орж ирсэн өдөр тутмын гүйлгээг санхүүгийн программд шивж оруулна 1.15. Авлага барагдуулалтын мэдээг насжилтын дагуу гаргаж санхүү алба, байгууллагын захиргаанд цаг хугацаанд гаргаж мэдээлэл хийж байна. /Тухай бүр/ 1.16. Авлага барагдуулалтын судалгаа, авлагын насжилтийн тайлан, УОО-ын судалгаа зэрэг тайлан баланс гаргахад өөрийн хариуцсан дансдын үлдэгдлийг балансын үлдэгдэлтэй тулгаж ерөнхий нягтлан бодогчоор баталгаажуулсан байна./Улирал бүр/ 1.17. Авлагын судалгаануудыг гарган найдваргүй авлага үүсэхээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг шуурхай авах, найдваргүй болж болзошгүй авлагын талаар байгууллагын захиргаанд танилцуулах, найдваргүй болсон авлагын баримтыг бүрдүүлж шүүхэд шилжүүлэх ажлыг хариуцана./Жилийн турш/ 1.18. Гүний ус ашигласаны хураамжийг тооцон төсөвт төлүүлэх ажлыг хариуцан ажиллана.Ус ашигалтын тайланг гаргаж тайлагнана. /Сар бүр/ 1.19. Борлуулалтын төлбөр тооцоотой холбоотой дотоодын хяналт шалгалтын ажлыг хариуцан хийнэ. Борлуулалтын анхан шатны баримт, карт хөтлөлт, гэрээ бүртгэл, программ хангамжийн бүртгэлийг тулган шалгаж зөрчлийг арилгуулах ажлыг хариуцна./жилийн турш/ 1.20. Байгууллагын орлого, авлага барагдуулалтын талаар ИТА-тай
--	--

	хамтран гэнэтийн үзлэг шалгалт хийж техник тоног төхөөрөмжтэй тулгалт хийх үнэ тариф тооцоололын талаар хяналт тавина. /Улиралд/ 1.21. Санхүүгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтийг үнэн зөв бодит байдлаар анхан шатны баримтыг үндэслэн цаг тухай бүрд хийнэ. /Сар бүр/ 1.22. Нягтлан бодох бүртгэлийн болон салбарын онцлогт тохирсон программ хангамжийг шинэчлэх, сайжруулах, тайлан тооцооны ажил хөдөлмөрийг хөнгөвчлөх, тайлангийн хавсралт маягтуудыг боловсронгуй болгоход санал өгнө. /Тухай бүр/ 1.23. Нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой арга аргачлал, заавар, хууль, дүрэм, журам, тогтоол, шийдвэр бусад баримт бичгийг судалж, өөрийн мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж ажиллана. /байнга/ 1.24. Үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн төсөв, төлөвлөгөө, үзүүлэлт, тариф, цалин хөлс бусад нууцад хамаарах бичиг баримтын нууцлалыг чанд хадгална. /байнга/ 1.25. Архивын хуулийн дагуу баримтыг архивт шилжүүлэх, электрон хэлбэрээр боловсруулсан тайлан мэдээг зөөврийн хардад файл болгон хадгална. Авлагын тооцооны баримтууд, НББүртгэл, борлуулалтын тайлангуудын хуудсыг дугаарлан үднэ. /сар, улирал, жил/ 1.26. Сар бүрийн борлуулалтын орлогын тайланг борлуулалтын төрөл, зүйл тус бүрээр гаргаж, ерөнхий нягтлан бодогчоор хянуулж байна. 1.27. Анхан шатны бүртгэл хөтлөлтийг боловсронгуй болгох талаар санаачлага гаргах. 1.28. Борлуулалтын мэргэжилтэн, байцаагч нарын ажлыг хянаж шалгаж өдөр тутмын ажлын үүрэг даалгаварыг өгөх, биелэлтийг шаардана. Ажлын байрны 2 дугаар үндсэн зорилтын хүрээнд: 2.1. Борлуулалтын ажилтан нарт санхүүгийн болон маркетингийн чиглэлээр сургалт зөвлөгөөн өгнө. /Жилийн турш/ 2.2. Борлуулалтын тайлангийн анхан шатны маягт бөглөх, акт бичих, санал хүсэлт, өргөдөл гаргах, хүлээн авах, тэдгээрийг шийдвэрлүүлэх арга замыг зааж, эргэлтийн хүснэгт хөтлөх, гэрээний заалтын хэрэгжүүлэлт, алдангийн тооцоог бодох аргачлалыг зааж сургахад заавар зөвлөгөөн өгч ажиллана. /Жилийн турш/ 2.3. Үйлчилгээний хүрээг өргөтгөх, чанарыг дээшлүүлэх, орлогын хэмжээг нэмэгдүүлэх замаар үр ашгийг дээшлүүлэхтэй холбогдсон асуудлыг боловсруулан хамт олны саналыг тусгаж байгууллагын захиргаанд тавина. /Жилийн турш/ 2.4. Бараа материалын нягтлан бодогчийг амарсан, эзгүй үед орлон ажиллаж бараа материалын тайлан тооцоог бодно. Ажлын байрны тодорхойлолттой танилцсан байна. /Тухайн үед/ 2.5 Айл өрхүүдийн сар бүрийн дулаан, цэвэр бохир усны бичилт, төлөлтийг өдөр бүр орон сууцны программд оруулж үлдэгдэлийг баталгаажуулах. 2.6. Борлуулмын тайлангуудын анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар борлуулалтын ажилтануудын сарын үр дүнгийн шагналын хэмжээг тогтооход, тэдний бүртгэл тооцооны ажлын оролцоог тодорхойлж, ерөнхий нягтлан бодогчоор дамжуулан өөрийн саналаа өгнө. /Сар бүр/ 2.7. Байгууллагын дотоод хяналт шалгалтыг хариуцсан ажлынхаа чиглэлээр гэнэтийн үзлэг шалгалт зохион байгуулах илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь засуулах, заавар зөвлөмж өгөх, орлого, авлагатай холбогдсон төлбөр тооцооны ажилтнуудаас хууль дүрэм зөрчих, тайлан чанаргүй буруу хийсэн, хоцроосон, орлогын мөнгийг зүй бусаар ашиглах, мэдээ тайлан будлиантуулах, ямар нэгэн ажилтны буруугаас болж үргүй зардал гаргасныг хууль дүрэм журамд
--	--

	зохицуулан нөхөн төлүүлэх ба хариуцлага хүлээлгэх тухай саналыг цаг алдалгүй боловсруулан байгууллагын захиргаанд тавьж шийдвэрлүүлнэ./Тухайн үед/ 2.8. Байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогчоос цаг үеийн асуудалтай холбогдуулан өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж эргэж мэдэгдэнэ./Тухай бүр/ 2.9. Ёс зүйн зөрчил болон хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргахгүй ажиллахын тулд өөрийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ./Жилийн турш/ 2.10. Ажлын төлөвлөгөө гарган ажиллаж ажлын тайланг тогтмол бичиж байна. /сар, улирал,жил/ 2.11. Компьютерийн үзлэг үйлчилгээ, сүлжээний асуудлыг мэргэжлийн хүмүүсээр тогтмол хийлгэж ,ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хариуцана./Өдөр бүр/ 2.12. Байгууллагын хэмжээнд зохиогдох цаг үеийн ажилд идэвхтэй оролцоно./Тухай бүр/ 2.13. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүүгийн тайланг Эрчим хүчний зохицуулах хороо ба Хот сууриний ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг Зохицуулах зөвлөлд улирал тутамд гаргаж тушаахад өөрийн хариуцсан дансдын мэдээлэлийг гаргаж өгнө. Ажлын байрны 3 дугаар үндсэн зорилтын хүрээнд: 3.1. Гэрээсээ ажилд ирж буцах маршрутыг өөрөө гарган холбогдох ажилтнаар батлуулан ажил олгогчид өгөх, гэрийн байршил өөрчлөгдөх бүрт энэ заалтыг хэрэгжүүлэн ажиллана. 3.2. Томилолтоор ажиллахдаа архи согтууруулах ундаа хэрэглэх, хувийн тээврийн хэрэгслээр зорчихыг хориглоно.Зайлшгүй тохиолдолд байгууллагын удирдлага, ХАБЭА хариуцсан мэргэжилтэнд хэлж зааварчилгаанд гарын үсэг зурсанаар зөвшөөрөгдсөнд тооцно. 3.3. Галын аюулгүй байдлыг хангаж ажиллана. 3.4. Байгууллагын ажилтан бүр ХАБЭА-н талаар дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд: 3.4.1. ХАБЭА-н холбогдох стандарт, журам, дүрэм, заавар, мөн түүнчлэн технологийн горимыг чанд мөрдөх, барилга байгууламж, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн болон бусад хорт ба аюултай бодис, материал, тээврийн хэрэгсэл болон бусад үйлдвэрлэлийн хэрэгслийг аюулгүй, зөв ашиглах, тэдгээрт тоноглогдсон хамгаалалтын ба аюулгүйн хэрэгслийг салгах, солих, авахгүй байх бөгөөд шаардлагатай үед тэдгээрийг хэрхэн зөв ашиглах талаар мэддэг байх; 3.4.2. ХАБЭА-н сургалтад хамрагдаж, шалгалт өгөх, зааварчилгаа авах, ажил үүргээ аюулгүй, осол эндэгдэлгүй гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар, арга барил эзэмших, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс сэргийлэх, болзошгүй ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшиж сурах; 3.4.3. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад ХАБЭА-н стандарт, журам, дүрэм, заавар зөрчигдсөн болон амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар шууд харьяалагдах албан тушаалтанд мэдэгдэж аюулгүй байдлыг хангуулах, удирдах албан тушаалтны зүгээс хууль тогтоомжид нийцүүлэн тавьсан ХАБЭА-н шаардлагыг биелүүлэх; 3.4.4. Ажлын байрны ХАБЭА-н эрсдлийг удирдах, хяналтын арга
--	--

	хэрэгслийн талаар мэдэх, ажлын байранд болон ажил гүйцэтгэх явцад илэрсэн аливаа аюул, эрсдэл, гарсан аюултай тохиолдлын талаар шууд харьяалагдах албан тушаалтанд мэдээлэх, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх; 3.4.5. Ажил үүргээ биелүүлэх явцад ажлын тусгай хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгслийг зөв, бүрэн гүйцэд, зориулалтын дагуу хэрэглэж эрүүл мэндээ хамгаалах, жил бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орж, эмчийн өгсөн зааврын дагуу нөхөн сэргээх эмчилгээ хийж байх; 3.4.6. Ажил эхлэхээс өмнө эрсдлээ үнэлэх буюу ээлжийн туршид ажлын байр, багаж, тоног төхөөрөмж, агааржуулалтын систем, гэрэлтүүлэг, хамгаалалтын хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үзэж, шалгах. Илэрсэн зөрчил дутагдлын талаар ажил удирдагчид мэдээлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авахуулах;ХАБЭА-н I шатны үзлэг хийж, зөрчлийг арилгуулах 3.4.7. ХАБЭА-н нөхцөл, үйлдвэрлэлийн аюулгүй байдалд шаардлагыг тогтоосон дүрэм, журам, зааврын шаардлагуудтай зөрчилдсөн нөхцөл байдал илэрсэн, мөн түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөгдөөгүй тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхгүй байх; 3.4.8. Харьяалагдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр ажлын байр болон ажиллаж буй тоног төхөөрөмжийг хараа хяналтгүй орхихгүй байх, хөндлөнгийн хүмүүс тоног төхөөрөмжийг залгах боломжийг хязгаарлах арга хэмжээ авах;
--	---

В. “АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА”

Ажлын байранд тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага	Боловсрол	Дээд
		Мэргэжил	Санхүү, нягтлан бодох бүртгэл
		Мэргэшил	-
		Туршлага	-Мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан байх
	Ур чадвар	- Хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай /MS-WORD, EXCEL Сمارт-борлуулалтын программ, юникус–баланс программ, Үндсэн хөрөнгө, цалин, материал борлуулалтын программууд.	
	Тусгай шаардлага		Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн байх, Багаар ажиллах, нууц хадгалах, удирдах, удирдуулах зарчмыг баримтлах, эерэг хандлага, зөв төлөвшилтэй, ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, ажлын ачаалал даах,

Г. “АЖЛЫН БАЙРНЫ ХҮЧИН ЗҮЙЛС”

Харилцах объект /хүрээ, уялдаа холбоо/	Байгууллагын дотор	Байгууллагын гадна
	Байгууллагын нийт ажилчид	Харилцагч байгууллагын

	холбогдох ажилтнууд
--	---------------------

Ажлын үр дүнгийн талаар ажил эрхлэгчийн хүлээх хариуцлага	Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод журам, ТАД, ААД, ГАУСД болон ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хөдөлмөрийн сахилгын, захиргааны болон эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ Ажлын хариуцлага алдсанаас учруулсан эд хөрөнгийн хохирлыг бүрэн хариуцна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг сахиж мөрдөөгүй, хариуцсан ажлаа ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэхгүйгээс зөрчил дутагдал гаргасан тохиолдолд хариуцлага хүлээнэ. Ажлын байранд архи уусан, танхайн сэдэлтэй үйлдэл хийсэн тохиолдолд хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болно.
--	---

Ажлын байрны нөөц хэрэгсэл	Санхүү	Батлагдсан тарифт цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал
	Эд хөрөнгө	Картаар хүлээлгэн өгсөн эд хөрөнгө
	Хүн хүч	
	Бусад	
Ажлын байрны нөхцөл		Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллана

